

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛООР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

/Өргөдлийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2019.11.20

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлан”-г 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ХЭГ/3000 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудал тус бүрээр гаргасан болно. Мөн бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийг хяналтаас хасах тухай Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн саналыг хавсаргав.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Монгол Улсын хуулиар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн 101 хуулийн 509 хэсэг, заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс хяналтанд авч, мэдээллийн санд бүртгэсэн болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар 57 хуулийн 206 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 30 хуулийн 109 хэсэг, заалт буюу 21.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 80 хуулийн 400 хэсэг, заалт буюу 78.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Харин өмнөх онуудад хяналтаас хасагдсан 41 хуулийн 97 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль	Хэсэг, заалт
1	2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	101	509
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	57	206
	- Хяналтанд байгаа	30	109
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	41	97
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	80	400

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 30 хуулийн 109 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 16 хуулийн 28 хэсэг, заалт буюу 25.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 24 хуулийн 37 хэсэг, заалт буюу 33.9 хувь нь хэрэгжих шатанд, 19 хуулийн 25 хэсэг, заалт буюу 22.9 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 1 хэсэг, заалт буюу 1.0 хувь нь хэрэгжээгүй, 10 хуулийн 18 хэсэг, заалт буюу 16.5 хувь нь хугацаа болоогүй мэдээ ирүүлсэн байна.

2019 оны эхний хагас жилийн байдлаар Өргөдлийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл болгосон Монгол Улсын хууль батлагдаагүй бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй болно.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 80 тогтоолын 268 заалтыг хяналтанд авсан.

2019 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 41 тогтоолын 85 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 20 тогтоолын 49 заалт буюу 18.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 63 тогтоолын 219 заалт буюу 81.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 21 тогтоолын 36 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Тогтоол	Заалт
1	2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	80	268
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	41	85
	- Хяналтанд байгаа	20	49
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	21	36
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	63	219

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн Улсын Их Хурлын 20 тогтоолын 49 заалтаас давхардсан тоогоор 11 тогтоолын 17 заалт буюу 34.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 7 тогтоолын 19 заалт буюу 38.8 хувь нь хэрэгжих шатанд, 5 тогтоолын 12 заалт буюу 24.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 2 хувь нь хэрэгжээгүй байна.

2019 оны эхний хагас жилийн байдлаар Өргөдлийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл болгосон Монгол Улсын Их Хурлын тогтоол батлагдаагүй бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй болно.

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООДЫН ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хороодын тогтоолын хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хороодоос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 98 тогтоолын 668 заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

2019 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 33 тогтоолын 138 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтанд байгаа 19 тогтоолын 51 заалт буюу 7.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 91 тогтоолын 617 заалт буюу 92.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

		Тогтоол	Заалт
1	2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	98	668
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	33	138
	- Хяналтанд байгаа	19	51
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	29	87
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	91	617

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 19 тогтоолын 51 заалтаас 5 тогтоолын 7 заалт буюу 13.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 14 тогтоолын 28 заалт буюу 54.9 хувь нь хэрэгжих шатанд, 8 тогтоолын 12 заалт буюу 23.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 3 тогтоолын 4 заалт буюу 7.9 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна. Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 29 тогтоолын 87 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

4.2. Өргөдлийн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Өргөдлийн байнгын хорооны 20 тогтоолын 117 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд байгаа тус Байнгын хорооны 5 тогтоолын 28 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 18 тогтоолын 89 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	Өргөдлийн байнгын хорооны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	20	117	100
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	5	28	23.9
Үүнээс:			
- Бүрэн хэрэгжсэн	4	6	21.4
- Хэрэгжих шатанд	4	14	50
- Хэрэгжилт хангалтгүй	2	5	17.9
- Хэрэгжээгүй	-	-	-
- Үнэлэх боломжгүй	3	3	10.7

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 5 тогтоолын 28 заалтаас давхардсан тоогоор 4 тогтоолын 6 заалт буюу 21.4 хувь нь бүрэн хэрэгжсэн, 4 тогтоолын 14 заалт буюу 50 хувь нь хэрэгжих шатанд, 2 тогтоолын 5 заалт буюу 17.9 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 10.7 хувь нь үнэлэх боломжгүй байна.

Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн тогтоолын хэрэгжилтийн талаар дараах мэдээллүүдийг сонссон байна. Үүнд:

- Өргөдлийн байнгын хорооны 2016 оны “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг 2019.05.22-ны өдөр сонссон;
- Өргөдлийн байнгын хорооны 2018 оны “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Байгаль орчин, аялал жуучлалын сайдын мэдээллийг 2019.10.09-ний өдөр сонссон;
- Өргөдлийн байнгын хорооны 2019 оны “Монгол Улсын Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх тухай” 02 дугаар хуралдааны тэмдэглэлээр Барилга, хот байгуулалтын сайдын мэдээллийг 2019.05.08-ны өдөр сонссон.

4.3. Мэдээнд гарсан зөрчил

Тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтанд байгаа нийт 20 тогтоолын 117 заалтаас 18 тогтоолын 89 заалт буюу 76.1 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байгаа нь Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэхээр байна. Тухайлбал,

№	Өргөдлийн байнгын хорооны тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй тогтоолын заалт
1	Засгийн газарт чиглэл өгөх тухай /2015.06.03 №10/	1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 2 дахь заалт;
2	Засгийн газарт чиглэл өгөх тухай /2015.06.03 №11/	1.8/, 2 дахь заалт;
3	Засгийн газарт чиглэл өгөх тухай /2015.06.17 №12/	2 дахь заалт;
4	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2016.11.23 №03/	1.7/, 1.8/ дахь заалт;
5	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2016.12.14 №04/	1.1/, 1.2/, 1.3/, 2 дахь заалт;

6	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2016.12.21 №05/	1.5/ дахь заалт;
7	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2017.02.01 №02/	1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 1.6/, 1.7/, 2 дахь заалт;
8	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2017.05.02 №03/	1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 1.6/, 2 дахь заалт;
9	Монгол Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоол, Өргөдлийн байнгын хорооны 2017 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар тус Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан Засгийн газарт үүрэг өгсөн /2017.11.15 №02/ хуралдааны тэмдэглэлийн	1, 2, 3, 4 дэх заалт;
10	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2018.02.06 №01/	1, 2, 3, 4, 5, 6 дахь заалт;
11	1995 оноос өмнө тогтоолгосон тэтгэврийн хэмжээ бага, тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх, нэг удаагийн буцалтгүй тусламжийг нөхөн олгуулах зэрэг асуудлаар ирүүлсэн өргөдлийн талаар тус Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан Засгийн газарт чиглэл өгсөн /2018.06.12 №01/ хуралдааны тэмдэглэлийн	1, 2, 3 дахь заалт;
12	Чиглэл өгөх тухай /2018.06.12 №04/	1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 1.10, 1.11, 1.12, 2.1, 2.2, 2.3, 3.1, 4 дэх заалт;
13	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2018.06.27 №05/	1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 2 дахь заалт;
14	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2018.06.27 №06/	1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 2 дахь заалт;
15	Засгийн газарт чиглэл өгөх тухай /2018.10.24 №07/	1.1/, 1.2/, 1.3/, 2 дахь заалт;
16	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийн нийгмийн халамж, урамшуулал, “Алдарт эх” одонгийн асуудлаар ирүүлсэн өргөдлийн талаар хэлэлцэж Засгийн газарт үүрэг өгсөн Байнгын хорооны /2019.04.16 №01/ хуралдааны тэмдэглэлийн	1, 2, 3 дахь заалт;
17	Түрээсийн орон сууцны хөтөлбөр, журам, бүртгэлтэй холбоотой асуудлаарх өргөдлийн дагуу сонссон мэдээлэлтэй холбогдуулан Засгийн газарт үүрэг өгсөн Байнгын хорооны /2019.05.08 №02/ хуралдааны тэмдэглэлийн	2, 3, 4, 5 дахь заалт;
18	Засгийн газарт чиглэл өгөх тухай /БОХХААБХ/ӨБХ/ 2019.05.28 №04/01/	1.1/, 1.2/, 1.3, 1.4/, 1.5/, 2 дахь заалт.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Өргөдлийн байнгын хорооны 4 тогтоолын 6 заалтыг хяналтаас хасах санал ирүүлсныг хавсралтаар хүргүүлэв.

ЗУРГАА. САНАЛ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулж тайлбарлаагүй орхигдуулсан, тус Байнгын хорооны 18 тогтоолын 89 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

2/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлэх, хэрэгжилтийн хувь хэмжээг өмнөхөөс бууруулж үнэлэх, шинээр хяналтанд авсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй зэрэг зөрчил байна.

3/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тус Байнгын хорооны 2017, 2018 онуудын тогтоолын хэрэгжилтийн мэдээг ирүүлэхгүй байдал давтагдаж байна.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ
/2019 оны эхний хагас жилийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2015.06.17 №12	1.5.Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлж байгаа талбайд тухайн компани газар чөлөөлөхөд зарцуулсан хөрөнгө, болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл хийгдсэн байдал зэргийг харгалзан цэцэрлэг, сургууль болон бусад нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж барих ажлыг төсөл хэрэгжүүлэгч компанид концессын гэрээгээр гүйцэтгүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх;	Барилга, хот байгуулалтын яам Тус яам нь чиг үүргийн дагуу Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх эрх зүйн орчинг сайжруулах арга хэмжээг авч ажиллаж байгаа ба энэхүү ажлын хүрээнд Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан батлагдсан 7 дүрэм, журам, зааврыг батлуулсан. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийн хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж байгаа болно.
2.	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016.01.12 №16	1.3/ Ашигт малтмалыг олборлох, боловсруулахад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үндэсний стандартыг бий болгож мөрдүүлэх, уурхайн хаалтыг Европын холбоо болон өндөр хөгжилтэй орнуудын жишигт нийцүүлэх, хариуцлагатай уул уурхайн зарчмыг бүх уул уурхайн үйлдвэрлэлд нэвтрүүлэх,	Байгаль орчин, аялал жуулчлалын яам Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоолоор “Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам”, “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ыг тус тус баталсан. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 8 дугаар сарын 17-ний өдрийн А/226, А/182 тоот хамтарсан тушаалаар “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал”, Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний загвар, мэдээний маягыг баталсан. Нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хүлээн авах, мэдээллийг нэгтгэх, хууль бусаар ашигт малтмал ашиглагч иргэн аж ахуйн нэгжийн тоог багасгах, илд далд хэлбэрээр зөвшөөрдөг байдлыг таслан зогсоох боломжтой болсон.

		үнэлэх арга, аргачлалыг батлан мөрдүүлэх;	
3.	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016.11.23 №03	1.6/ Төв цэвэрлэх байгууламжид бохирдолтой ус нийлүүлж буй 8 чиглэлийн 225 үйлдвэрлэлийн хаягдал усны стандартад хяналт тавих;	<p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар</p> <p>а/ 2019 оны эхний хагас жилийн байдлаар төв цэвэрлэх байгууламжид бохирдолтой ус нийлүүлж байгаа 8 чиглэлийн 225 үйлдвэрийн хаягдал усны стандартад хяналт тавихад арьс шир боловсруулах үйлдвэрүүдээс хаягдаж байгаа технологийн хаягдал усанд хийсэн шинжилгээгээр үйлдвэрүүдээс 2019 онд урьдчилан цэвэрлэх байгууламжид хаягдаж байгаа технологийн хаягдал усанд химийн хэрэгцээт хүчилтөрөгч 3.1 дахин, умбуур бодис 4.01 дахин, рН 0,5 хувь их сульфид хэвийн түвшинд, төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэгдэж байгаа хаягдал усанд химийн хэрэгцээт хүчилтөрөгч 1.4 дахин, умбуур бодис 1.2 дахин их сульфид, рН хэвийн хэмжээнд гарсан байгаа нь өмнөх 2018 онтой харьцуулахад урьдчилан цэвэрлэх байгууламжид нийлүүлэгдэж буй технологийн хаягдал усанд умбуур бодис 0.11-ээр, химийн хэрэгцээт хүчил төрөгч 2 дахин буурч, сульфид хэвийн хэмжээнд харин рН-ын бохирдол 0.5%-иар их буюу өмнөх онтой ижил түвшинд байна. Мөн 2019 онд төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэгдэж байгаа хаягдал усанд умбуур бодис 0.4%-иар буурч сульфид, рН хэвийн түвшинд, химийн хэрэгцээт хүчил төрөгч 0.2%-иар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>б/ Ноос ноолуурын үйлдвэрүүдээс гарч байгаа технологийн хаягдал усанд шинжилгээ хийхэд 2017 онд умбуур бодис 4.06 дахин их, химийн хэрэгцээт хүчил төрөгч 7.7 дахин их, сульфид, рН хэвийн хэмжээнд, 2018 онд химийн хэрэгцээт хүчилтөрөгч 3.5 дахин, умбуур бодис 4.2 дахин их, рН хэвийн, 2019 онд химийн хэрэгцээт хүчилтөрөгч 3.1 дахин их, умбуур 1.1 дахин рН болон сульфидын хэмжээ хэвийн гарсан бөгөөд 2019 оны бохирдлын түвшинг 2017 онтой харьцуулахад умбуур бодис 2.96%-иар, химийн хэрэгцээт хүчилтөрөгч 4.6%-иар буурсан, сульфид болон рН хэвийн хэмжээнд байна.</p> <p>в/ Өлөн боловсруулах үйлдвэрийн хаягдал бохир уснаас дээж авч НМХГ-ын төв лабораторид шинжилгээ хийхэд 6 үйлдвэрийн бохир усны химийн хэрэгцээт хүчилтөрөгч, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч стандартын шаардлага хангаагүй харин авто угаалга болон бусад чиглэлийн үйлдвэрийн бохир ус стандартын түвшинд гарч байна.</p>
		1.9/ Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангаж, туул голын энгийн хамгаалалтын бүсэд олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын яам</p> <p>БОАЖСайдын 2017 оны 3 дугаар сарын 9-ны А/54 тоот тушаалаар Нийслэлийн нутаг дэвсгэр дэх Туул голын хамгаалалтын бүсэд газар ашиглаж байгаа болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашигшлагж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглалтыг судалгааг хийх зохих арга хэмжээ авах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Энэхүү ажлын хэсгийн хүрээнд Нийслэлийн БОАЖГ болон Нийслэлийн МХГ хоёр хамтран хяналт шалгалтын ажил зохион байгуулан ажилласан. Үүний дагуу Нийслэлийн Засаг даргын захирамжийн 2017 оны 8 дугаар сарын 21-ны А/609 тоот тушаалаар Туул голын хамгаалалтын бүсэд хамрагдсан уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй 62 аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг цуцалсан ба шинээр олгохгүй байхаар шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/609 дүгээр захирамжаар нийслэлийн хэмжээнд Усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалтай түгээмэл тархацтай ашигт малтмалын 46 тусгай зөвшөөрөл цуцлагдаж, 2017 онд Нийслэлийн</p>

		хайгуулын 11, ашиглалтын 39 тусгай зөвшөөрлийг цуцлах, 116.9 га талбайд нөхөн сэргээлт хийлгэх;	нутаг дэвсгэрт техникийн нөхөн сэргээлт 65.35 га, биологийн нөхөн сэргээлт 17.62 га, 2018 онд техникийн нөхөн сэргээлт 92.1 га, биологийн нөхөн сэргээлт 12.6 га, нийт 187.67 га талбайд тус тус хийгдсэн.
		1.10/ Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэгт заасан усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хамрах хүрээг өргөтгөх, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, цуцлах эрхийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;	Байгаль орчин, аялал жуулчлалын яам Туул голын хамгаалалтын бүсэд газар ашиглаж байгаа болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглалтын судалгааг гаргах, хууль бус газар ашиглалтын талаар авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Туул голын эрэг дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалт, олборлолтын байдалтай газар дээр нь явж танилцан, газар болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын талаарх судалгааг хийн газар эзэмших, ашиглах эрх бүхий нийт 21,790 нэгж талбар, нийт 4672.77 га талбай бүхий 56 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл байгааг тогтоосон. Нийслэлийн Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд хяналт, шалгалтын ажлыг 4-6-р сард хийж гүйцэтгэн, 74 аж ахуйн нэгжид 546 заалтаар албан шаардлага хүргүүлэн, 21 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоож, 44 аж ахуйн нэгжид 31 680.0 мян.төгрөгийн торгууль тавих, 42.72 га газарт техникийн нөхөн сэргээлт, 2.83 га газарт биологийн нөхөн сэргээлт хийлгэж, нийслэлийн Засаг даргын 2017 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн А/609 захирамжаар нийт 96 аж ахуйн нэгж, үүнээс Туул голын хамгаалалтын бүстэй давхцалтай түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий 46 аж ахуйн нэгжийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах арга хэмжээг авсан.
4.	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016.12.21 №05	1.2/ Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд аймаг, сум, дүүргийн засаг дарга болон мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй байх зохицуулалтыг холбогдох хуульд оруулах, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн хариуцлагыг чангатгах чиглэлээр холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах санал боловсруулах;	Байгаль орчин, аялал жуулчлалын яам УИХ-аас 2015 онд Эрүүгийн хууль, 2017 онд Зөрчлийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар хариуцлага, торгуулийн хэмжээ өөрчлөгдсөн. УИХ-аас 2012 онд баталсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.3-д заасан үндэслэлээр Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлуулаагүй аж ахуйн нэгжид ашиглалт олгохгүй болсон.
Нийт 4 тогтоолын 6 заалт			

